



ШҮҮХИЙН ШИЙДВЭРИЙН ХУРААНГУЙ (Иргэний эрх зүйн маргаан¹)

ҮҮРГЭЭ ХУГАЦААНД НЬ БИЕЛҮҮЛЭЭГҮЙ, ЭСХҮЛ ҮҮРЭГ ГҮЙЦЭТГЭХ ХУГАЦАА БОЛСНЫГ ҮҮРЭГ ГҮЙЦЭТГҮҮЛЭГЧ САЛУУЛСНААС ХОЙШ ҮҮРГЭЭ БИЕЛҮҮЛЭЭГҮЙ ТОХИОЛДОЛД ҮҮРЭГ ГҮЙЦЭТГЭГЧИЙГ ХУГАЦАА ХЭТРҮҮЛСЭН ГЭЖ ҮЗНЭ

САНАМЖ: Энэхүү хураангуй нь шүүхийн шийдвэрийг орлохгүй ба хууль хэрэглээний нэгдмэл байдлыг тогтооход дэмжлэг үзүүлэх, шүүхийн шийдвэрийн үндэслэлийг сурталчлах болон иргэд, олон нийтийн эрх зүйн мэдлэгт зориулсан бөгөөд хураангуйд ашигласан шийдвэр нь хяналтын шатны шүүхийн тогтоол болно.

Шүүхийн шийдвэрийн дугаар: 001/ХТ2025/00133

Шүүхийн шийдвэрийн огноо: 2025 оны 06 сарын 27-ны өдөр

Шийдвэрийн төлөв: Хяналтын шатны шүүх давж заалдах шатны шүүхийн магадлалыг хүчингүй болгон, анхан шатны шүүхийн шийдвэрийг хэвээр үлдээж, нэхэмжлэгчийн гомдлыг хангаж шийдвэрлэсэн.

ХЭРГИЙН ТУХАЙ ТОВЧ

Нэхэмжлэгч “Ш” ХХК нь хариуцагч “Н” ХХК-д холбогдуулан 3,808,806,030 төгрөг гаргуулах нэхэмжлэл гаргаж үндэслэлээ “..талуудын хооронд 2021 онд NM-A2191 Г/97 тоот, 2022 онд NM-A2224 Г/68 тоот бараа болон бүтээгдэхүүн худалдан авах гэрээг тус тус байгуулж, захиалгат дизель түлш цаг тухайд нь нийлүүлсээр ирсэн. Гэрээний 4.2-т зааснаар хариуцагч нь дизель түлш зээлээр худалдан авсан тохиолдолд үнийг худалдан авсан өдрөөс хойш хуанлийн 60 хоногийн дотор бүрэн төлж барагдуулах үүргийг хүлээсэн. Гэвч хариуцагч худалдан авсан дизель түлшний төлбөрөө гэрээнд заасан хугацаанд бүрэн төлөөгүй. Гэрээний дагуу тооцсон алданги нь 2023.11.10-ны өдрийн байдлаар 5,876,676,730.60 төгрөг болсон бөгөөд гүйцэтгээгүй үүргийн үнийн дүнгийн 50%-тай тэнцэх хэмжээнд 1,269,602,010 төгрөг байна. Иймд хариуцагчаас үндсэн төлбөр 2,539,204,020 төгрөг, алдангид 1,269,602,010 төгрөг, нийт 3,808,806,030 төгрөгийг гаргуулж өгнө үү” гэжээ.

Хариуцагч “Н” ХХК нэхэмжлэлийн шаардлагын зарим хэсгийг эс зөвшөөрч компанийн буруугаас төлбөрийг хугацаанд нь төлөхгүй хойшлуулаагүй, гагцхүү нийлүүлсэн дизель түлшний хэмжээ гэрээнд заасан хэмжээнд хүрээгүйгээс үүдэлтэйгээр төлөх төлбөрийн хэмжээ тодорхойгүй болж, үүнийг тодорхой болгох үүднээс харилцан зөвшилцөн хойшлуулж, 2022.09.20-ны өдрийг хүргэсэн гэж маргажээ.

ХУУЛЬ ХЭРЭГЛЭЭ, ШҮҮХИЙН ШИЙДВЭР

¹ Шүүхийн шийдвэрийг бүрэн эхээр нь үзэх холбоос:
https://shuukh.mn/single_case/10868?daterange=2025/01/01%20-%202025/10/13%20&id=3&court_cat=1&bb=1



1. **Анхан шатны шүүх** нэхэмжлэлийн шаардлагын зарим хэсгийг хангаж шийдвэрлэхдээ: "...Зохигчийн хооронд Иргэний хуулийн 243 дугаар зүйлд² заасан худалдах- худалдан авах гэрээ байгуулагдсан, нэхэмжлэгч "Ш" ХХК нь гэрээгээр хүлээсэн үүргээ хэрэгжүүлж, нэхэмжилж буй үнийн дүнд таарах дизель түлшийг хариуцагч талд хүлээлгэн өгсөн болох нь баримтаар тогтоогдсон тул хариуцагч үнийг төлөх үүрэгтэй. Нэхэмжлэгч нь хариуцагчийг төлбөрөө төлөхийг удаа дараа шаардаж, төлбөрийн хугацаа хэтэрсэн талаар сануулж байсан болох нь баримтаар тогтоогдсон. Мөн бодитой гарсан хулгайн гэмт хэргийг шалгаж дууссан, үүнтэй холбоотой үнийн дүнг нэхэмжлэлээс хасч, үлдсэн дүнгээс алдангийг тооцсон мөн **алдангийг хуульд зааснаар нэхэмжилж байх тул нэхэмжлэгч "Ш" ХХК нь алданги шаардах эрхтэй, хариуцагч "Н" ХХК нь нэхэмжлэгчид алдангийг төлөх үүрэгтэй.** Иргэний хуулийн 232.8-д³ заасны дагуу алдангийг 269,602,010 төгрөгөөр багасгаж тооцох үндэслэлтэй. Иймд хариуцагчаас гэрээний үндсэн төлбөрт 2,539,204,020 төгрөг, алдангийн төлбөрт 1,000,000,000 төгрөг нийт 3,539,204,020 төгрөгийг гаргуулж, нэхэмжлэгчид олгож, нэхэмжлэлээс үлдэх 269,602,010 төгрөгийг хэрэгсэхгүй болгож шийдвэрлэх нь зүйтэй" гэж дүгнэжээ.
2. **Давж заалдах шатны шүүх** анхан шатны шүүхийн шийдвэрт өөрчлөлт оруулж шийдвэрлэхдээ "...Нийлүүлсэн дизель түлшний төлбөрт 2,539,204,020 төгрөг гаргуулсан анхан шатны шүүхийн дүгнэлт хуульд нийцсэн. Дизель түлшний хулгайн асуудлыг эрүүгийн журмаар шалгасантай холбоотойгоор нэг талаас нэхэмжлэгч нийлүүлэлтээ зогсоож, нөгөө талаас **хариуцагчийн төлбөр төлөх хугацаа, хэмжээний талаар талууд тодорхой санал гаргаж хэлэлцээ хийж байсан тул уг хугацаанд хариуцагчийг үүрэг гүйцэтгэх хугацааг хэтрүүлсэн гэж дүгнэх үндэслэлгүй.** Иргэний хуулийн 222 дугаар зүйлийн 222.1.1⁴, 222.1.2-т⁵ зааснаар үүргээ хугацаанд нь биелүүлээгүй, эсхүл үүрэг гүйцэтгэх хугацаа болсныг үүрэг гүйцэтгүүлэгч сануулснаас хойш үүргээ биелүүлээгүй тохиолдолд үүрэг гүйцэтгэгчийг хугацаа хэтрүүлсэн гэж үзэх боловч дээрх үндэслэлээр хариуцагчийг хугацаа хэтрүүлсэн гэж үзэхгүй. Иймд **нэхэмжлэгч нь хугацаа хэтрүүлсний хариуцлага болох алданги төлөхийг хариуцагчаас шаардсан нь Иргэний хуулийн 232 дугаар зүйлийн 232.6 дахь хэсэгт⁶ нийцээгүй байх тул алдангид холбогдох шаардлагыг хэрэгсэхгүй болгох үндэслэлтэй"** гэжээ.

² Иргэний хуулийн 243 дугаар зүйлийн 243.1. "Худалдах-худалдан авах гэрээгээр худалдагч нь биет байдлын доголдолгүй, эрхийн зөрчилгүй хөрөнгө, түүнтэй холбоотой баримт бичгийг худалдан авагчийн өмчлөлд шилжүүлэх буюу бараа бэлтгэн нийлүүлэх, худалдан авагч нь худалдагчид хэлэлцэн тохирсон үнийг төлж, худалдан авсан хөрөнгөө хүлээн авах үүргийг тус тус хүлээнэ."

³ ИХ-ийн 232 дугаар зүйлийн 232.8. "Анзын хэмжээ илт их байвал хэргийн нөхцөл байдлыг харгалзан шүүх түүнийг багасгаж болно."

⁴ ИХ-ийн 222 дугаар зүйлийн 222.1.1. "Үүрэг гүйцэтгэгч үүргээ хугацаанд нь биелүүлээгүй бол хугацаа хэтрүүлсэн гэж үзнэ."

⁵ ИХ-ийн 222 дугаар зүйлийн 222.1.2. "Үүрэг гүйцэтгэх хугацаа болсныг үүрэг гүйцэтгүүлэгч сануулснаас хойш үүргээ биелүүлээгүй бол хугацаа хэтрүүлсэн гэж үзнэ"

⁶ ИХ-ийн 232 дугаар зүйлийн 232.6. "Хууль болон гэрээнд заасан хугацаа хэтрүүлсэн тал нь хоног тутамд гүйцэтгээгүй үүргийн үнийн дүнгийн 0,5 хувиас хэтрэхгүй хэмжээгээр төлөхөөр тогтоосон анзыг алданги гэнэ."



3. **Хяналтын шатны шүүх хэргийг шийдвэрлэхдээ** хэргийн үйл баримтын талаарх анхан шатны шүүхийн дүгнэлтийг буруутгасан давж заалдах шатны шүүхийн магадлалд заасан үндэслэл Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 40 дүгээр зүйлийн 40.1⁷, 40.2-т⁸ нийцээгүй үүний улмаас тус шүүх Иргэний хуулийн 222 дугаар зүйлийн 222.1.1, 222.1.2, 232 дугаар зүйлийн 232.4⁹, 232.6, 232.8-д заасныг буруу тайлбарлан хэрэглэсэн байх тул магадлалыг хүчингүй болгосон. Давж заалдах шатны шүүх “...Дизель түлшний хулгайн асуудлыг эрүүгийн журмаар шалгасантай холбоотойгоор нэг талаас нэхэмжлэгч нийлүүлэлтээ зогсоож, нөгөө талаас хариуцагчийн төлбөр төлөх хугацаа, хэмжээний талаар талууд тодорхой санал гаргаж хэлэлцээ хийж байсан тул уг хугацаанд хариуцагчийг үүрэг гүйцэтгэх хугацааг хэтрүүлсэн гэж дүгнэх үндэслэлгүй” гэж үзэн **алдангийн шаардлагыг бүхэлд нь хэрэгсэхгүй болгосон нь үндэслэлгүй болжээ.** (12)¹⁰
4. Иргэний хуулийн 222 дугаар зүйлийн 222.1.1, 222.1.2-т зааснаар үүргээ хугацаанд нь биелүүлээгүй, эсхүл үүрэг гүйцэтгэх хугацаа болсныг үүрэг гүйцэтгүүлэгч сануулснаас хойш үүргээ биелүүлээгүй тохиолдолд үүрэг гүйцэтгэгчийг хугацаа хэтрүүлсэн гэж үздэг. Анхан шатны шүүх дээр дурдсан үйл баримтыг үндэслэн зохигч төлбөрийн асуудлаар харилцан ярилцаж байсан боловч нэг шийдэлд хүрч үр дүн гараагүй тул хариуцагчийн алданги төлөхгүй гэсэн татгалзал үндэслэлгүй, нэхэмжлэгч нь нийлүүлсэн дизель түлшний үнэ болох хугацаа хэтрүүлсний алданги шаардах эрхтэй гэж дүгнэснийг буруутгах үндэслэл тогтоогдсонгүй. **Анхан шатны шүүх хэргийн дээрх нөхцөл байдлыг харгалзан үзэж алдангийн хэмжээг багасгасан нь Иргэний хуулийн 232 дугаар зүйлийн 232.8-д заасныг зөрчөөгүй байна.** (16.4)
5. Давж заалдах шатны шүүх алданги гаргуулах шаардлагыг бүхэлд нь хэрэгсэхгүй болгохдоо хулгайн гэмт хэрэг гарахаас өмнө хариуцагч төлбөр төлөх үүргээ хугацаанд нь бүрэн гүйцэтгээгүй хугацаа хэтрүүлсэн нөхцөл, эрүүгийн хэргийн нөхцөл байдал тодорхой болохтой холбоотой төлбөрийг хэрхэн төлөх асуудлаар харилцан санал солилцож байсан боловч тохиролцоонд хүрээгүй, энэ хугацаанд төлбөрийн үүргээ гүйцэтгэхийг шаардсан нэхэмжлэгчийн шаардлага, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад 8490 литр дизель түлш хулгайлсан эрүүгийн хэрэг шийдвэрлэгдсэн, уг хэргийн хулгайн эд зүйл болсон 8490 литр дизель түлшийг тухайн үед хариуцагч тал хураан авч ашигласан, **эдгээр байдлыг харьцуулан үзээгүй нь учир дутагдалтай, хэргийн үйл баримтыг хуульд заасан журмын дагуу тогтоож, Иргэний хуулийн 232 дугаар зүйлийн 232.4, 232.6, 232.8-д заасныг зөв тайлбарлан хэрэглээгүй гэж дүгнэнэ.** (17)

⁷ Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 40 дүгээр зүйлийн 40.1. “Шүүх хэргийн оролцогчийн гаргасан нотлох баримтыг тал бүрээс нь бодитойгоор харьцуулан үзсэний үндсэн дээр нотлох баримтыг өөрийн дотоод итгэлээр үнэлнэ.”

⁸ ИХШХШТХ-ийн 40 дүгээр зүйлийн 40.2. “Нотлох баримтыг тухайн хэрэгт хамааралтай, ач холбогдолтой, үнэн зөв, эргэлзээгүй талаас нь үнэлнэ.”

⁹ ИХ-ийн 232 дугаар зүйлийн 232.4. “Анз нь торгууль, алданги гэсэн төрөлтэй байна. Анзын нийт дүн гүйцэтгээгүй үүргийн үнийн дүнгийн 50 хувиас хэтэрч болохгүй.”

¹⁰ “Хууль хэрэглээ, шүүхийн шийдвэр” хэсгийн өгүүлбэрийн төгсгөлд бичигдсэн хаалт доторх дугаарлалт нь шүүхийн эх шийдвэрийн цогцолборын дугаар болно